

Нийгмийн тухай мэдлэг

БАГШ:Д.ОЮУН

Сэдэв 7: Нийгмийн хамгаалал

Сэдвийн зорилго: Нийгэм эдийн засгийн амьдрал, түүний онцлог, эдийн засгийн тухай ойлголт болоод түүний хэлбэр, бүрдүүлэгч гол элементүүдийн талаар цэгцтэй мэдлэг олж авахад оршино.

Түлхүүр үгс:

- Ажилтны нийгмийн баталгаа
- Нийгмийн хамгаалал
- Нийгмийн хангамж
- Нийгмийн даатгал
- Нийгмийн даатгалын сан
- Нийгмийн халамжийн тогтолцоо
- Нийгмийн эмзэг бүлэг

ХҮН АМЫН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ ГЭДЭГ НЬ

Нийгмийн бүх гишүүдийн амьдралын хэв нөхцөлийг хангахад чиглэгдсэн улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцааны цогцолбор гэж ойлгож болно.

Нийгмийн бүх гишүүдийг хөдөлмөрлөх боломж талаас нь

1. Ажилтан (хөдөлмөр идэвхитэй эрхэлж буй хэсэг),
2. Ажилгүйчүүд,
3. Нийгмийн эмзэг хэсэг гэсэн 3 хэсэгт бүлэгт хамааруулдаг.

Ажилтаны нийгмийн баталгаа

Ажилтаны нийгмийн баталгааг хангана гэдэг нь төр засгаас хөдөлмөрийн хөлсны доод хэмжээг тогтоож мөрдүүлсэн байхаас гадна хөдөлмөрлөх нөхцөлийг (хэвийн эрүүл ахуй, аюулгүй орчин, хөдөлмөр хамгаалал, ажил амралтын горим дэглэм гэх мэт) сайжруулах, тодорхой шалтгаанаар хөдөлмөрийн чадвараа бүр мөсөн буюу хагас алдах, тахир дутуу болох ажилгүйдэлд орох тэрчлэн өндөр наслах зэрэг болзошгүй болон зайлшгүй тохиолдох нөхцөлд учрах хүндрэл бэрхшээлийг хөнгөлөхтэй холбогдсон баталгааг бүрдүүлж өгнө гэсэн үг.

Харин ажилгүйчүүдийн нийгмийн хамгаалал гэдэг нь ажилгүйдлийн тэтгэмж олгох, ажлын байраар хангах, мэргэжил эзэмшихэд нь туслах зэрэг асуудлууд багтана.

Нийгмийн эмзэг хэсгийн нийгмийн баталгааг хангах буюу нийгмийн хамгаалал гэдэг нь

- Тэтгэвэр тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амжиргааг дээшлүүлэх
- Амьдрал ядуу, бага орлоготой айл өрх иргэдэд туслах сан байгуулж, амьдралаа дээшлүүлэх боломжтой ядуучуудад бага хүүтэй зээл олгож аж ахуй эрхлэх, ажил хийхэд туслах
- Амьдралын хувьд нэн ядуу иргэдэд буцалтгүй тусламжийн хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх
- Бие даан амьдарч өөртөө үйлчлэх чадваргүй иргэдийг төрийн ивээлд авч зориулалтын байгууллагад хамруулан үнэ төлбөргүй асарч сувилах, хооллох, хоноглох боломж бүрдүүлэх, амьдралын наад захын хэрэгцээтэй зүйлс түлээ нүүрс олж нийлүүлэн туслах, тэдэнд үйлчлэх мэргэжлийн ажилтаныг сургаж бэлтгэх гэх зэрэг амьдралын наад захын баталгааг хангадаг.

Нийгмийн хангамж

Нийгмийн хангамж нь хүн амын эмзэг хэсэгт хамрагдах иргэдэд тэтгэвэр тэтгэмж олгох, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амжиргааг дээшлүүлэх агуулга бүхий нийгмийн хамгаалалын арга хэмжээ юм.

Нийгмийн хангамжийн бодлого нь улс орон бүрт өөр өөрийн онцлогтой хэдий ч

1. Даатгалын тогтолцоо,
2. Нийгмийн халамж, тусламж гэсэн 2 үндсэн хэсэгт хуваан авч үзэж болно.

1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО

Манай улсын хувьд нийгмийн хангамжийн шинэ тогтолцоо 1995 онд УИХ-аас Нийгмийн даатгалын багц хуулийг батлан гаргаснаар бий болсон юм.

Нийгмийн даатгал гэдэг нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалыг санг бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, даатгуулагч нас барахад түүний асрамжад байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээг хэлнэ. Мөн нийгмийн даатгалын санг аж ахуйн нэгж, байгууллага, даатгагч 2 хамтарч бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

Нийгмийн даатгалын хэлбэр:

Заавал даатгуулах



- Аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч
- Төрийн албан хаагч
- Аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэний малыг тэдэнтэй байгуулсан гэрээний дагуу маллаж байгаа малчин

Сайн дураараа даатгуулах



- Дээрхи заавал даатгагдсанаас бусад хувиараа хөдөлмөр эрхлэх замаар үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхэлж байгаа иргэд
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон чөлөөт уран бүтээлчид
- Хувийн аж ахуйтан-малчид, тариаланчид

Нийгмийн даатгалын сан



2. Нийгмийн халамжийн ТОГТОЛЦОО

2005 онд УИХ-аар батлан гаргасан “Нийгмийн халамжийн тухай” шинэчлэн найруулсан хуулинд “Нийгмийн халамж гэдэг нь мөрдөж буй хууль тогтоомж, журам зааврын дагуу нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт тэтгэмж олгох, тэдгээрийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээ”-г хэлнэ гэжээ.

Нийгмийн эмзэг бүлэг гэдэгт

- Тэжээн тэтгэх төрөл садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие ахмад настан,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн,
- Хүнд нөхцөлд байгаа хүүхэд,
- Ядуу, нэн ядуу амьдралд олон хүүхэдтэй өрх толгойлсон эх(эцэг) хамаардаг байна

Нийгмийн халамжийн тэтгэврийн төрөл:

- Ахмад настны халамжийн тэтгэвэр
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр
- Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх(50 насанд хүрсэн эцэг) хамаардаг байна.
- Хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж

Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн төрөл

- Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж,
- Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж,
- Хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж

Анхаарал хандуулсанд баярлалаа.

